

**“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
2024 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 2 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар01

“ГТХЗНТ” УТҮГ

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 1 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
ЗСХ	9	7	1	-	1	-	-	-	93.3
ТНУАСХ	16	15	-	-	-	1	-	-	95.6
ГХБАБМХ	6	6	-	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>	<b>31</b>	<b>28</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>95.8</b>

**Дүгнэлт**

Нэгжүүд 2024 оны 1 дүгээр сард нийт төлөвлөсөн 31 ажлаас 93.6 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 6.4 хувийг хэрэгжүүлж дуусаагүй зорилтот түвшинд хүрээгүй 2 ажил (ХАБЭА-н үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, Нэгдсэн зурмагийн хүрээнд суурь бүтцүүдийн саналыг авч Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага (ОСЖД)-ын гишүүн орнуудын зөвлөгөөнд оролцох бэлтгэл ажлыг хангаж ажиллах) байна.

Тайлант сард Зам, тээврийн хөгжлийн сайдын 2 удаагийн шуурхай хуралдаанаас нийт 13 үүрэг даалгавар өгснөөс хэрэгжилт 77 хувьтай байна. (ХАСХОМ мэдүүлэх 1, RFID холбоотой 2 үүрэг даалгавар биелээгүй)

Тайлант сард нийт 35 хариутай бичиг бүртгэгдэж, 22 бичгийг хугацаанд нь, 2 бичгийг хугацаа хоцроож шийдвэрлэсэн байна. (ЗТХЯ-ны ТЗУГ, БТГ-аас ирүүлсэн бичгийг ТНУАСХ нэг хоног хугацаа хоцроосон)

Албан бичгийн шийдвэрлэх хугацааг сунгасан 2, шийдвэрлэх шатанд 9, баримт бичиг шийдвэрлэлт төвийн хэмжээнд 72.7 хувь байна.

### **Санал зөвлөмж**

Төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 2024.01.25-ны өдөр батлагдсан, түүнчлэн хөдөлмөрийн дотоод журмын 5.1.5, 5.1.6-д зааснаар Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн нэгжийн гүйцэтгэлийн болон сарын төлөвлөгөө баталж хэрэгжүүлнэ гэж заасны дагуу дараах ажлыг нэгжийн гүйцэтгэлийн болон сарын төлөвлөгөөнд тусгаж төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээ авч, холбогдох ажилтанд хариуцуулж ажиллах. Үүнд:

1. Нэгдсэн зурмагийн гүйцэтгэл (суурь бүтэц тус бүрээр тээвэрлэсэн ачааны хэмжээ)-д сар, улирал тутам дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авч үр дүнг яаманд танилцуулах;

2. Нэгдсэн зурмагийн дүнгийн хурлыг улирал тутам зохион байгуулж, зурмагийн тасалдлын зорилтот үзүүлэлтийг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тээврийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийг сайжруулах арга хэмжээг тохиролцох;

3. Нэгдсэн технологийн горимыг хэрэгжүүлэхэд ГТХЗНТ дээр шаардлагатай ажилагсдыг бэлтгэн ажиллуулах;

4. Шинэчлэн батлагдсан хуулийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн орон тоо, бүтцийг бэлтгэх;

5. Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулах;

6. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг хөтлөх, боловсруулах заавар боловсруулах;

7. Монгол Улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний дугаарлалт хийх заавар боловсруулах;

8. Өртөөний технологийн горим боловсруулах заавар боловсруулах;

9. Нэгдсэн технологийн горимыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжилтийг хангах;

10. Өртөө зөрлөгийн кодын мэдээллийн сан бүрдүүлж дүн шинжилгээ хийх, өртөө, зөрлөгт код олгох зааврыг батлуулах;

11. Хоног, долоо хоног, сар, улирлын мэдээллийг хүргүүлэх механизмыг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

12. Төмөр замын тээврийн салбарт ашиглагдаж буй объект, үйл ажиллагааны үндсэн болон мета өгөгдлийн жагсаалт, каталоги гаргах;

13. Ажилтнуудад тоон гарын үсгийн гэрчилгээг шинэчлэн олгох;

14. RFID хяналтын технологийн ашиглалтын судалгаа хийж, систем нэвтрүүлэхэд баримтлах суурь баримт бичиг, ажлын даалгавар боловсруулах;

15. Төмөр замын байгууллагуудын тээвэрлэлтийн программ хангамж, цахим системийн нарийвчилсан ажлын даалгаврыг боловсруулах;

16. Хөдлөх бүрэлдэхүүний улсын нэгдсэн тооллого зохион байгуулах, бүртгэл хийх, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд төвийн дүрэм нэмэлт оруулах саналыг ЗТХЯ-нд хүргүүлж шийдвэрлүүлэх;

17. ТР ТС 001/2011 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын техникийн стандартыг орчуулан боловсруулах ажлыг эхлүүлэх, үр дүнд хүргэх;

18. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө баталж ЗТХЯ-д хүргүүлэх;


19. Баримт нягтлан шалгах комиссын дүрэм, 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулж батлуулах;

20. Гэрчилгээжүүлэлтийн цахим системээр ирүүлсэн өргөдөл хүсэлтүүд бичиг хэрэгт төвлөрч бүртгэгдэхгүй байгаад анхаарч ажлын хэсэгт шилжүүлсэн хүсэлт (албан бичиг)-ийг PDF форматаар албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэнд шилжүүлж бүртгүүлэх, баримт бичгийн тайлан мэдээний тоонд оруулах;

21. Тайлан мэдээг тоо баримт, тушаал, албан бичгийн огноо, дугаар зэрэг мэдээллээр баталгаажуулах, үг үсэг, найруулгын алдааг хянаж байх.

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

ТНУАСХ-ИЙН ДАУТОГ



Ж.АЛИМАА

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ



Э.ОСОРЖАМАА